

2018 оны санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайлан

Чойбалсан хот

2019,01,12

“Дорнод Авто зам” Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай 1284.75км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ,БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол, Хэрлэнгийн доод дээд 2 гүүр,Улзын голын нийт 4 бетон хийц бүхий гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 4 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

Манай компани нь 2018 оны байдлаар 557,4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 540,1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 17,3 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч өмнөх онд 15,1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан учраас энэ оны санхүүгийн тайлангаар хуримтлагдсан ашгийн зөрүү тайлант үе, өмнөх үеийн зөрүүний өссөн дүнгээр 2,2 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан. 2018 онд Зам,Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын 542,6 сая төгрөгийн гэрээний ажил хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллалаа.Мөн аймгийн төвийн 4 чиглэл, Дэхтийн замд 86,0

сая төгрөгийн хайрган хучилттай замын ажлыг хийж гүйцэтгэлээ.


Компани дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 29 ажиллагсадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 106,2 сая төгрөг, НДШимтгэлд 12,7 сая төгрөг, материал түүхий эд худалдан сэлбэг хэрэгсэл болон шатахууны зэрэг шууд үйлдвэрлэлийн зардалд 330,4 гаруй сая төгрөгийг зарцуулав. Мөн НӨАТатварт 23,0 сая төгрөг,бусад тавар шимтгэлд 7,8 сая төгрөгийн татвар төлөлтийг тооцож аймаг орон нутгийн татварт төвлөрүүлэн ажиллав. 2018 онд хийж гүйцэтгэх гэрээт ажлуудаа хугацаанд нь хийж гүйцэтгэн санхүүгийн жилд өмнөх үүссэн алдагдлаа бүрэн нөхөн ажиллах боломжтой ажиллалаа.Компани Хөлөнбуйрын шуурхай ажлын хэсэгт эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр шинээр өвлийн байшин,хашаа худалдан авч,граж бартж ашиглааланд орууллаа.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс,орлого үр дүнгийн тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлан,бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн

Нягтлан бодогч



Ц.ОТГОН